



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 408

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 20 нэрийн нийт 2,321,173,921.94 (хоёр тэрбум гурван зуун хорин нэгэн сая нэг зуун далан гурван мянга есөн зуун хорин нэгэн төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 617,109,000.00 (зургаан зуун арван долоон сая нэг зуун есөн мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Ганхүлэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001400

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 9 дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

"БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл		Шинэчлэн тогтоосон нийт үнэ		Цаашид ашиглах хугацаа (жил)
						(төгрөг)	(төгрөг)	(төгрөг)	(төгрөг)	
1	Манхан-зэрэг гол баг 15 кВ-ын АШ	2010-12-01	км	13.50	7,383,047.93	99,671,147.06	94,687,500.00	10		
2	Мянгад-Цагаанбулан баг 6 кВ-ын АШ	2010-12-01	км	12.00	6,775,225.67	81,302,708.04	77,237,500.00	10		
3	Булган-баянсудал баг 10кв-ын шугам	2010-12-01	км	1.90	9,732,603.68	18,491,946.99	17,567,000.00	10		
4	Тоолуурын шалгах зөөврийн багаж	2010-01-05	ш	1.00	20,985,456.00	20,985,456.00	6,295,500.00	10		
5	6 кВ-ын Мянгад АШ	1997-12-31	км	16.20	15,477,050.00	250,728,210.00	50,145,500.00	10		
6	6 кВ-ын АШ Буянт сум	2008-02-01	км	19.00	19,161,301.00	364,064,719.00	72,812,000.00	10		
7	6 кВ-ын Ховд, Жаргалант - Нисэх АШ	2003-09-30	км	13.00	16,404,248.00	213,255,224.00	42,651,000.00	10		
8	6 кВ-ын Ховд, Жаргалант сум- Парк АШ	2003-09-30	км	2.62	16,404,248.00	42,979,129.76	8,595,000.00	10		
9	6 кВ-ын Ховд, Жаргалант сум Тахилт АШ	2003-09-30	км	1.96	18,091,434.00	35,459,210.64	7,091,000.00	10		
10	Ховд, Жаргалант сум Бугат 6 кВ-ын АШ	2003-08-07	км	1.43	18,091,434.00	25,870,750.62	5,174,000.00	10		
11	Ховд, Жаргалант сум Баатархайрхан 6 кВ-ын АШ	2003-08-07	км	3.70	16,496,100.54	61,035,572.00	12,207,000.00	10		
12	Ховд, Жаргалант сум Элсэн толгой 6 кВ-ын АШ	2003-08-07	км	13.44	16,366,497.00	219,965,719.68	43,993,000.00	10		
13	Ховд, Жаргалант сум Үйлдвэрийн район 6 кВ-ын шугам	2004-05-23	км	0.70	15,819,481.00	11,073,636.70	2,214,000.00	10		
14	Ховд, Жаргалант сум Доод чиглэл 6 кВ-ын АШ	2003-05-20	км	3.00	16,500,933.33	49,502,799.99	9,900,000.00	10		
15	Ховд, Жаргалант сум Дээд чиглэл-2 6 кВ-ын АШ	2003-09-30	км	5.00	16,555,572.00	82,777,860.00	16,555,000.00	10		
16	Ховд, Ховд сум 6 кВ-ын АШ	2004-07-18	км	36.23	19,186,029.02	695,109,831.46	139,022,000.00	10		
17	Ховд, Булган сум 10кВ-ын ЦДАШ	1986-12-31	км	8.95	800,000.00	7,160,000.00	1,432,000.00	10		
18	Ховд, Булган сум 10 кВ-ын тулгуур	1986-12-31	ш	140.00	270,000.00	37,800,000.00	7,560,000.00	10		
19	Цаг бүртгэлийн программ	2015-01-15	ш	1.00	1,440,000.00	1,440,000.00	720,000.00	10		
20	ХАБ-ын төстийн программ	2016-12-01	ш	1.00	2,500,000.00	2,500,000.00	1,250,000.00	10		
						<b>2,321,173,921.94</b>	<b>617,109,000.00</b>			
						<b>(хоёр тэрбум гурван зуун хорин нэгэн мянга нэг зуун далан гурван мянга есөн зуун хорин нэгэн мөнгө)</b>		<b>(зургаан зуун арван долоон сая нэг зуун есөн мянган)</b>		

Нийт дүн